

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 06

№ 24/ТУЗ/49

Улаанбаатар хот

“ Охин компани байгуулах зөвшөөрөл олгох тухай ”

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.14.26 дахь заалт, Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны 12-р сарын 06-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тээвэр ложистикийн чиглэлээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотод үйл ажиллагаа эрхлэх хувь нийлүүлсэн охин компанийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан нөхцөлөөр үүсгэн байгуулж, тус хавсралтад заасан үнийн дүнгээр хөрөнгө оруулахыг зөвшөөрсүгэй.
2. Охин компани шинээр үүсгэн байгуулах, хуулийн дагуу бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой бүхий л харилцаанд Компанийг төлөөлөх, гарын үсэг зурах, холбогдох шаардлагатай арга хэмжээг авч ажиллах эрхийг Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д олгосугай.
3. Тогтоолын хэрэгжилт, охин компани үүсгэн байгууахтай холбоотой явцын мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГАНЗОРИГТ